



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Боловсролын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Боловсролын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.“Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын “Боловсролын яам” гэсэн 6 дахь хэсгийн 4-т “Боловсролын газар” гэснийг “Ерөнхий боловсролын газар” гэж, мөн тогтоолын хавсралтаар баталсан “Яамдын орон тооны хязгаар”-ын 6 дахь мөрний “104” гэснийг “110” гэж, “Засгийн газрын агентлаг байгуулах тухай” 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолын 2 болон 8 дахь заалтын “171” гэснийг “165” гэж тус тус өөрчилсүгэй.


3.Боловсролын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын сайд П.Наранбаярт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БОЛОВСРОЛЫН САЙД

П.НАРАНБАЯР



Засгийн газрын 2024 оны 08 дугаар  
сарын 14-ний өдрийн 42 дугаар  
тогтоолын хавсралт

БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН  
ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Оршил

Боловсролын яам (цаашид "яам" гэх)-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "хөтөлбөр" гэх)-ийн зорилго нь Засгийн газрын танхим, Боловсролын сайд (цаашид "сайд" гэх)-ын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын хөгжлийн стратеги, төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, бодлогын удирдамжаар хангах, түүнд нийцсэн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, салбарын хөгжлийг мэдээлэл технологи, нотолгоонд суурилсан тоо, мэдээллээр дэмжих, төрийн захиргааны удирдлагаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, хяналт шалгалт хэрэгжүүлэх асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратегийн загвар, зохион байгуулалтын бүтцийн нэгж, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлоход оршино.

1.2.Үндэслэл

Энэ хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан "“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын баримт бичиг, “Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоол, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-г тус тус үндэслэл болгов.

1.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин

Хөтөлбөрийг доор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Боловсролын ерөнхий хууль;
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль;
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль;
- Хүүхэд хамгааллын тухай хууль;
- Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль;
- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль;
- Дээд боловсролын тухай хууль;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;
- Олон улсын гэрээний тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль;
- Цахим гарын үсгийн тухай хууль;
- Кибер аюулгүй байдлын тухай хууль;
- Статистикийн тухай хууль;

-Хөдөлмөрийн тухай хууль;

-Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль;

-Номын сангийн тухай хууль;

-Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;

-холбогдох бусад.

#### 1.4.Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад хууль, эрх зүйн орчны өөрчлөлт, засаглал болон өөрчлөлтийн удирдлага, байгууллагын өөрчлөлтийн онол, арга зүй, олон улсын жишиг, өмнөх хөтөлбөрүүдийн ололт, сургамжид үндэслэн нийтлэг арга зүйг ашиглалаа. Мөн салбарын өмнө тулгамдаж байгаа асуудал, тэргүүлэх чиглэл, стратегийн зорилт, үйл ажиллагааны гол зорилт, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлоход хэрэглэдэг арга зүйг ашиглав.


#### 1.5.Яамны үүрэг, хариуцлагын хуваарь

Яам нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, боловсролын талаарх хууль тогтоомж, бодлого, стратегийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг, хариуцлага хүлээж, сайд болон Засгийн газарт дээр дурдсан чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгч, бүх талын дэмжлэг үзүүлнэ. Яам нь өөрийн хариуцсан чиг үүргийн асуудлаар Засгийн газарт зөвлөхийн үүрэг гүйцэтгэж, хариуцлага хүлээнэ. Хариуцсан чиг үүргийн дагуу иргэдэд шуурхай, мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

#### 1.6.Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг оновчтой, бүрэн тодорхойлох нь яамны үйл ажиллагааны стратегийг тодорхойлоход чухал ач холбогдолтойг харгалзан энэ хэрэгцээний эх үүсвэрт дараах үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг хамруулав:

## Боловсролын яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



### Хоёр.Яамны үйл ажиллагааны стратеги

#### 2.1.Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, "Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030", Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, улсын хөгжлийн төлөвлөгөө, Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлогыг төлөвлөх, зохицуулах, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, харьяа агентлагийн үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангаж, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

#### 2.2.Яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Яам дараах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

##### 2.2.1.боловсролын салбарын нэгдсэн бодлогыг тодорхойлох;

2.2.2.дээд боловсролыг өрсөлдөх чадвартай, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөц бэлтгэх бодлогыг тодорхойлж, удирдлага, зохицуулалтаар хангах;

2.2.3.хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, түншлэлд суурилсан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын бодлогыг тодорхойлох, удирдлага, зохицуулалтаар хангах;

2.2.4.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын болон тэгш хамран сургах бодлого тодорхойлох, удирдлага, зохицуулалтаар хангах;

2.2.5.Цахим боловсролын бодлого тодорхойлох, удирдлага, зохицуулалтаар хангах;

2.2.6.Боловсролын салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх;

2.2.7.Боловсролын салбарын санхүү, эдийн засгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлж, хөгжүүлэх;

2.2.8.Боловсролын салбарын болон яамны үйл ажиллагааны дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээг чанаржуулах, эрсдэлийн удирдлага, зөвлөмжөөр хангах;

2.2.9.Боловсролын стандартын хэрэгжилтийг хангуулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийж, эрсдэлийн удирдлага, зөвлөмжөөр хангах;

2.2.10.Боловсролын салбарын удирдлагын манлайллыг хангах, яамны төрийн захиргааны болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын чадавхыг сайжруулах, эрх зүйн дэмжлэг үзүүлэх.

### 2.3.Яамны үйл ажиллагааны эрхэм зорилго

Яамны эрхэм зорилго нь боловсролын салбарын үйл ажиллагааг хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэх, боловсронгуй болгох, бүх хүний сурч боловсрох эрхийг хангах, тэгш боломжийг бүрдүүлэх, зөв, оновчтой бодлогыг тодорхойлж төрт ёс, түүх, соёл, уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг, ёс зүйг дээдлэн сахисан, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг чадвартай, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эрүүл, хариуцлагатай, төлөвшсөн иргэнийг бэлтгэхэд оршино.

### 2.4.Яамны үйл ажиллагааны стратегийн зорилт

Боловсролын яам нь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгынхоо хүрээнд доор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1.боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл боловсруулах, батлуулах, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, салбар хоорондын уялдааг бодлогын удирдамжаар хангах, насан туршдаа суралцахуйн тогтолцоог хөгжүүлж бүх түвшний боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, бодлогын чиглэл боловсруулах, статистикийн маягт, аргачлалыг боловсронгуй болгох, батлуулах, хянах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, түгээх, суралцагчийн хоол, хүнсний эрүүл ахуй, илчлэг, норм, нормативыг боловсруулж, батлуулах;

2.4.2.дээд боловсролын сургалтын байгууллагын хөгжил, засаглал, магадлан итгэмжлэл, судалгаа, сургалт, сургалтын чанар, орчин, багш, оюутны

хөгжлийг боловсронгуй болгох чиглэлээр богино хугацааны төлөвлөгөө, дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, батлуулах, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангуулах, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт болон салбарын бодлого, хууль тогтоомж, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

2.4.3.мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын хөгжил, засаглал, магадлан итгэмжлэл, сургалтын чанар, орчин, багш, суралцагчийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл, ажил олгогч, мэргэжлийн холбоодын түншлэлийн хамтын ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр богино хугацааны төлөвлөгөө, дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, батлуулах, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангуулах, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт болон салбарын бодлого, хууль тогтоомж, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

2.4.4.сургуулийн өмнөх, ерөнхий болон тэгш хамран сургах боловсролын хөгжлийн чиглэлээр батлагдсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн удирдлага, зохицуулалтыг хангах чиглэлээр дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах;

2.4.5.цахим боловсролын хөгжлийн чиглэлээр бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, батлуулах, бодлогын удирдамжаар болон үйл ажиллагааг удирдлага, манлайллаар хангах, хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.4.6.боловсролын салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, гадаад улсад хүний нөөц бэлтгэх, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

2.4.7.боловсролын салбарын санхүү, эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл, төсөв боловсруулах, батлуулах, хөрөнгө оруулалт, төсвийн шинжилгээ хийх, салбар хоорондын уялдаа, бодлогын хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх, шинжилгээ хийх, мэдээллээр хангах;

2.4.8.боловсролын салбарын төсөв, орлого, зарлага, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, яам болон харьяа байгууллага, төслийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, харьяа байгууллагуудыг дотоод аудитын нэгдсэн удирдлага арга зүйгээр хангах;

2.4.9.иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний

актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх;

2.4.10.төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, байгууллагын соёлын өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлөвшүүлэх, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, байгууллага, салбарын бодлого, үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах.

## 2.5.Яамны үйл ажиллагааны гол зорилт

Стратегийн зорилтын хүрээнд доор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

### 2.5.1.Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1.боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого чиглэл тодорхойлох, хуулийн төсөл боловсруулах, батлуулах;

2.5.1.2.боловсролын салбар хоорондын бодлогын уялдааг хангаж, нэгдсэн төлөвлөлт хийх, удирдамжаар хангах;

2.5.1.3.боловсролын салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих урт, дунд хугацааны төсөл боловсруулах, донор болон хөгжлийн байгууллагуудын хамтын ажиллагааны зохицуулалтыг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах;

2.5.1.4.салбарын статистикийн маягт, аргачлалыг олон улсын аргачлалд нийцүүлэн боловсруулах, шинэчлэх, бодлого, төлөвлөлтөөр хангах, статистикийн мэдээллийн бүртгэлийн чанар, мэдээллийн нэгдсэн санд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, нэгтгэх, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, зөвлөх, үйлчилгээ үзүүлэх;

2.5.1.5.иргэний насан туршийн суралцахуйн хөгжлийн бодлого, төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах, удирдлага, зохицуулалтыг бодлогоор хангах, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.5.1.6.суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, хоол хүнсний эрүүл ахуй, илчлэг, норм, нормативыг боловсруулж, батлуулах, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх.

### 2.5.2.Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1.дээд боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн хэрэгжилтийг хангах журам, дүрэм болон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургалтын агуулга, үнэлгээг боловсронгуй болгох;

2.5.2.2.дээд боловсролын салбарын урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах;

2.5.2.3.дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг хангах, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.5.2.4.гадаадад болон гадаадаас бакалавр, магистр, докторт тэтгэлгээр суралцагчийн асуудлыг зохицуулах;

2.5.2.5.оюутны хөгжил, суралцах орчин нөхцөл, тэгш хамран сургах хөгжлийн бодлого, хууль, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах.

### 2.5.3.Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1.мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах, батлуулах, бодлогын удирдамж, арга зүйгээр хангах, хуулийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, журам, дүрэм, аргачлал болон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургалтын чанар, нийцлийг сайжруулах, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.5.3.2.мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд шаардагдах журам, дүрэм, аргачлал болон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах;

2.5.3.3.мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын бие даасан байдлыг хангах, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.5.3.4.мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэх, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх, суралцагчийн хөгжил хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах асуудлыг зохицуулах.

### 2.5.4.Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1.ерөнхий боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах, зохицуулалтыг хангах, шаардагдах журам, дүрэм, аргачлал, удирдамж эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургуулийн боловсролын чанар, тэгш хамран сургах, хүртээмжийг сайжруулах, сургуулийн насны хүүхдийн цогц хөгжлийг хангах, салбарын хүний нөөц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний удирдлага, зохицуулалтыг бодлогоор хангах, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.5.4.2.сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах, зохицуулалтыг хангах, шаардагдах журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургуулийн өмнөх боловсролын чанар, тэгш хамран сургах, хүртээмжийг сайжруулах, бага болон балчир насны хүүхдийн цогц хөгжлийг хангах, салбарын хүний нөөц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний удирдлага, зохицуулалтыг бодлогоор хангах, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.5.4.3. сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд тэгш хамран сургах, насан туршийн суралцахуйн хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, шаардагдах журам, дүрэм, аргачлал болон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургалтын хөтөлбөр, агуулга, үнэлгээ, сурах бичиг, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгаалал, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

#### 2.5.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1. боловсролын мэдээлэл технологийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, батлуулах, салбарын нэгдсэн мэдээлэл, удирдлага, суралцахуйн системийг нийтийн мэдээллийн дэд бүтцэд нийцүүлэн хөгжүүлэх, нээлттэй сургалтын болон мэдээллийн сан, мэдээлэл солилцоо, нууцлал, аюулгүй байдал болон дижитал дэд бүтцийг нэгдсэн бодлого, төлөвлөлтөөр хангах, цахим шилжилтэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, салбарын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад цахим хэлбэрээр хүргэх.

#### 2.5.6. Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.5.6.1. салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

2.5.6.2. олон улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулах, яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг хангах.

#### 2.5.7. Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.5.7.1. боловсролын салбарын төсвийн хүрээний мэдэгдэл, жил бүрийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлтийг нийгэм, эдийн засгийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан оновчтой боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх, салбарын харьяа байгууллагын төсвийг нэгтгэн боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын болон шилэн дансны хэрэгжилтийг хангах;

2.5.7.2. төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн сар, улирлын болон хөтөлбөр, арга хэмжээний хуваарилалт хийх, захиран зарцуулах, тайлагнах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зохицуулалтаар хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх;

2.5.7.3. гадаадын төсөл, хөтөлбөрийн төсвийн нэгдсэн төлөвлөлтийн зохицуулалтыг хангах, төрийн сантай харилцах;

2.5.7.4. салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх, худалдан авалтыг зохион байгуулах, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх, шинжилгээ хийх, мэдээллээр хангах.

#### 2.5.8. Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд:

2.5.8.1. боловсролын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, дотоод аудит хийх;

2.5.8.2. бодлогын баримт бичиг, хөтөлбөр, арга хэмжээний уялдаа холбоо, тэдгээрийн хэрэгжилтэд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

2.5.8.3. яамны болон харьяа байгууллага, төслийн нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ хийх, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.5.8.4. яамны болон харьяа байгууллага, төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ, дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

2.5.8.5. сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

2.5.8.6. салбарын байгууллагын дотоод аудит, хяналт-шинжилгээ, чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;

2.5.8.7. төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудитыг санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, явц, гарсан үр дүнд хийх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг хангах, тайлагнах;

2.5.8.8. салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мэдээллийн цахим санг бүрдүүлэх.

#### 2.5.9. Үйл ажиллагааны стратегийн 9 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.9.1. хуульд заасны дагуу хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавих, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг холбогдох хуульд заасны дагуу авч хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах;

2.5.9.2. хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2.5.9.3. хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандарт, тэдгээрийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг хэрхэн хэрэгжүүлж

байгааг судлан нэгтгэж, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг боловсронгуй болгох саналаа хүргүүлэх.

#### 2.5.10. Үйл ажиллагааны стратегийн 10 дугаар зорилтын хүрээнд:

2.5.10.1. яамны үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой, байдлыг хангах, яамны соёлын өөрчлөлтийг удирдах төрийн захиргааны төв байгууллага, харьяа байгууллагын удирдах ажилтны хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, удирдлагыг хэрэгжүүлэх, манлайллаар хангах;

2.5.10.2. яамны албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;

2.5.10.3. салбарын үйл ажиллагааны тайлан нэгтгэн гаргах, тогтоол, шийдвэрийн биелэлтийг нэгтгэх, тайлагнах;

2.5.10.4. салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр, гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулалтыг бусад хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, хууль тогтоомжийн мэдээллийн сан бүрдүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;

2.5.10.5. авлигаас сэргийлэх, соён гэгээрүүлэх, таслан зогсоох чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

2.5.10.6. яамны болон салбарын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах, түгээх.

#### 2.6. Үйл ажиллагааны зорилт

Яам нь үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлж, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тус тус нарийвчлан тусган хэрэгжүүлнэ.

## 2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Яамны үйл ажиллагааны стратегийн загварыг доор дурдсанаар тодорхойлж байна:

Эрхэм зорилго	Үйл ажиллагааны стратеги зорилт	Үйл ажиллагааны гол зорилт
<p>Яамны эрхэм зорилго нь боловсролын салбарын үйл ажиллагааг хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэх, боловсронгуй болгох, бүх хүний сурч боловсрох эрхийг хангах, тэгш боломжийг бүрдүүлэх, зөв, оновчтой бодлогыг тодорхойлж төрт уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг, ёс зүйг дээдлэн сахисан, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг чадвартай, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эрүүл, хариуцлагатай, төлөвшсөн иргэнийг бэлтгэхэд оршино.</p>	<p>боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл боловсруулах, батлуулах, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, салбар хоорондын уялдааг бодлогын удирдамжаар хангах, насан туршдаа суралцахуйн тогтолцоог хөгжүүлж бүх түвшний боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, бодлогын чиглэл боловсруулах, статистикийн маягт, аргачлалыг боловсронгуй болгох, батлуулах, хянах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, түгээх, суралцагчийн хоол, хүнсний эрүүл ахуй, илчлэг, норм, нормативыг боловсруулж, батлуулах;</p>	<p>-боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого чиглэл тодорхойлох, хуулийн төсөл боловсруулах, батлуулах;</p> <p>-боловсролын салбар хоорондын бодлогын уялдааг хангаж, нэгдсэн төлөвлөлт хийх, удирдамжаар хангах;</p> <p>-боловсролын салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих урт, дунд хугацааны төсөл боловсруулах, донор болон хөгжлийн байгууллагуудын хамтын ажиллагааны зохицуулалтыг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах;</p> <p>-салбарын статистикийн маягт, аргачлалыг олон улсын аргачлалд нийцүүлэн боловсруулах, шинэчлэх, бодлого, төлөвлөлтөөр хангах, статистикийн мэдээллийн бүртгэлийн чанар, мэдээллийн нэгдсэн санд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, нэгтгэх, нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, зөвлөх, үйлчилгээ үзүүлэх;</p> <p>-иргэний насан туршийн суралцахуйн хөгжлийн бодлого, төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах, удирдлага, зохицуулалтыг бодлогоор хангах, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;</p> <p>-суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, хоол хүнсний эрүүл ахуй, илчлэг, норм, нормативыг боловсруулж, батлуулах, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх.</p>
	<p>дээд боловсролын сургалтын байгууллагын хөгжил, засаглал, магадлан итгэмжлэл, судалгаа, сургалт, сургалтын чанар, орчин, багш, оюутны хөгжлийг боловсронгуй болгох чиглэлээр богино хугацааны төлөвлөгөө, дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, батлуулах, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангуулах, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт болон салбарын бодлого, хууль тогтоомж, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;</p>	<p>-дээд боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн хэрэгжилтийг хангах журам, дүрэм болон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургалтын агуулга, үнэлгээг боловсронгуй болгох;</p> <p>-дээд боловсролын салбарын урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах;</p> <p>-дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг хангах, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;</p> <p>-гадаадад болон гадаадаас бакалавр, магистр, докторт тэтгэлгээр суралцагчийн асуудлыг зохицуулах;</p> <p>-оюутны хөгжил, суралцах орчин нөхцөл, тэгш хамран сургах хөгжлийн бодлого, хууль, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах.</p>
	<p>мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын хөгжил, засаглал, магадлан итгэмжлэл, сургалтын чанар, орчин, багш, суралцагчийн хөгжил, хөдөлмөрийн зах</p>	<p>-мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах, батлуулах, бодлогын удирдамж, арга зүйгээр хангах, хуулийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, журам, дүрэм, аргачлал болон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургалтын чанар, нийцлийг сайжруулах, тэгш</p>

Яамны эрхэм зорилго нь боловсролын салбарын үйл ажиллагааг хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэх, боловсронгуй болгох, бүх хүний сурч боловсрох эрхийг хангах, тэгш боломжийг бүрдүүлэх, зөв, оновчтой бодлогыг тодорхойлж төрт уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг, ёс зүйг дээдлэн сахисан, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг чадвартай, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эрүүл, хариуцлагатай, төлөвшсөн иргэнийг бэлтгэхэд оршино.

зээл, ажил олгогч, мэргэжлийн холбоодын түншлэлийн хамтын ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр богино хугацааны төлөвлөгөө, дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, батлуулах, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангуулах, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт болон салбарын бодлого, хууль тогтоомж, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

сургуулийн өмнөх, ерөнхий болон тэгш хамран сургах боловсролын хөгжлийн чиглэлээр батлагдсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн удирдлага, зохицуулалтыг хангах чиглэлээр дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах;

цахим боловсролын хөгжлийн чиглэлээр бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, батлуулах, бодлогын удирдамжаар болон үйл ажиллагааг удирдлага, манлайллаар хангах, хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

боловсролын салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, гадаад улсад хүний нөөц бэлтгэх, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

боловсролын салбарын

хүртээмжийг нэмэгдүүлэх;  
 -мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд шаардагдах журам, дүрэм, аргачлал болон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургалтын чанар, нийцлийг сайжруулах, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх;  
 -мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын бие даасан байдлыг хангах, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;  
 -мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэх, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх, суралцагчийн хөгжил хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах асуудлыг зохицуулах.

-ерөнхий боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах, зохицуулалтыг хангах, шаардагдах журам, дүрэм, аргачлал, удирдамж эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургуулийн боловсролын чанар, тэгш хамран сургах, хүртээмжийг сайжруулах, сургуулийн насны хүүхдийн цогц хөгжлийг хангах, салбарын хүний нөөц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний удирдлага, зохицуулалтыг бодлогоор хангах, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;  
 -сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах, зохицуулалтыг хангах, шаардагдах журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургуулийн өмнөх боловсролын чанар, тэгш хамран сургах, хүртээмжийг сайжруулах, бага болон балчир насны хүүхдийн цогц хөгжлийг хангах, салбарын хүний нөөц, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний удирдлага, зохицуулалтыг бодлогоор хангах, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;  
 -сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд тэгш хамран сургах, насан туршийн суралцахуйн хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, шаардагдах журам, дүрэм, аргачлал болон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, сургалтын хөтөлбөр, агуулга, үнэлгээ, сурах бичиг, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгаалал, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

-боловсролын мэдээлэл технологийн бодлого, төлөвлөлтийг боловсруулах, батлуулах, салбарын нэгдсэн мэдээлэл, удирдлага, суралцахуйн системийг нийтийн мэдээллийн дэд бүтцэд нийцүүлэн хөгжүүлэх, нээлттэй сургалтын болон мэдээллийн сан, мэдээлэл солилцоо, нууцлал, аюулгүй байдал болон дижитал дэд бүтцийг нэгдсэн бодлого, төлөвлөлтөөр хангах, цахим шилжилтэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, салбарын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад цахим хэлбэрээр хүргэх.

-салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;  
 -олон улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулах, яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг хангах.

-боловсролын салбарын төсвийн хүрээний мэдэгдэл.

<p>Яамны эрхэм зорилго нь боловсролын салбарын үйл ажиллагааг хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэх, боловсронгуй болгох, бүх хүний сурч боловсрох эрхийг хангах, тэгш боломжийг бүрдүүлэх, зөв, оновчтой бодлогыг тодорхойлж төрт уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг, ёс зүйг дээдлэн сахисан, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг чадвартай, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эрүүл, хариуцлагатай, төлөвшсөн иргэнийг бэлтгэхэд оршино.</p>	<p>санхүү, эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл, төсөв боловсруулах, батлуулах, хөрөнгө оруулалт, төсвийн шинжилгээ хийх, салбар хоорондын уялдаа, бодлогын хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх, шинжилгээ хийх, мэдээллээр хангах;</p>	<p>жил бүрийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн төлөвлөлтийг нийгэм, эдийн засгийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан оновчтой боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх, салбарын харьяа байгууллагын төсвийг нэгтгэн боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын болон шилэн дансны хэрэгжилтийг хангах;</p> <p>-төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн сар, улирлын болон хөтөлбөр, арга хэмжээний хуваарилалт хийх, захиран зарцуулах, тайлагнах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зохицуулалтаар хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх;</p> <p>-гадаадын төсөл, хөтөлбөрийн төсвийн нэгдсэн төлөвлөлтийн зохицуулалтыг хангах, төрийн сантай харилцах;</p> <p>-салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх, худалдан авалтыг зохион байгуулах, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх, шинжилгээ хийх, мэдээллээр хангах.</p>
	<p>боловсролын салбарын төсөв, орлого, зарлага, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, яам болон харьяа байгууллага, төслийн нэгжүүдийн үйл ажиллагаанд, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, харьяа байгууллагуудыг дотоод аудитын нэгдсэн удирдлага арга зүйгээр хангах;</p>	<p>-боловсролын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, дотоод аудит хийх;</p> <p>-бодлогын баримт бичиг, хөтөлбөр, арга хэмжээний уялдаа холбоо, тэдгээрийн хэрэгжилтэд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;</p> <p>-яамны болон харьяа байгууллага, төслийн нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ хийх, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, дүгнэлт, зөвлөмж гаргах;</p> <p>-яамны болон харьяа байгууллага, төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ, дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх;</p> <p>-сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;</p> <p>-салбарын байгууллагын дотоод аудит, хяналт-шинжилгээ, чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;</p> <p>-төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудитыг санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, явц, гарсан үр дүнд хийх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хангаж ажиглах, тайлагнах;</p> <p>-салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мэдээллийн цахим санг бүрдүүлэх.</p>
	<p>иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан</p>	<p>-хуульд заасны дагуу хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавих, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг холбогдох хуульд заасны дагуу авч хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах;</p> <p>-хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар</p>

	<p>хяналтын бэхжүүлэх;</p> <p>ТОГТОЛЦООГ</p>	<p>хангах;</p> <p>-хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандарт, тэдгээрийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг хэрхэн хэрэгжүүлж байгааг судлан нэгтгэж, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг боловсронгуй болгох саналаа хүргүүлэх.</p>
	<p>төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, байгууллага, салбарын бодлого, үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах.</p>	<p>-яамны үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой, соёлтой байдлыг хангах, төрийн захиргааны төв байгууллага, харьяа байгууллагын удирдах ажилтны хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, удирдлагыг хэрэгжүүлэх, манлайллаар хангах;</p> <p>-яамны албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;</p> <p>-салбарын үйл ажиллагааны тайлан нэгтгэн гаргах, тогтоол, шийдвэрийн биелэлтийг нэгтгэх, тайлагнах;</p> <p>-салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр, гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулалтыг бусад хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, хууль тогтоомжийн мэдээллийн сан бүрдүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;</p> <p>-авлигаас сэргийлэх, соён гэгээрүүлэх, таслан зогсоох чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг удирдлагаар хангах;</p> <p>-яамны болон салбарын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах, түгээх.</p>

Гурав.Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

### 3.1.Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримталсан зарчим

Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав:

3.1.1.яамны стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2.эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх хэмжээтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх);

3.1.3.үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4.бүтцийн хувьд энгийн байх зарчим (яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжийг хүртэл хоёроос дээшгүй шат дамжлагатай байх);

3.1.5.тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүний нөөц болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байх);


3.1.6.улс төрөөс ангид байх зарчим (тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь эрхэлсэн сайд, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчид төвийг сахисан, өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй байх);

3.1.7.хангалттай чадавх, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

### 3.2.Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон яамны үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дараах ерөнхий тогтолцооны загвартай байна:

### Боловсролын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



### 3.3. Яамны зохион байгуулалтын бүтэц

Боловсролын яамны үйл ажиллагааны стратеги болон үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг доор дурдсанаар тодорхойлж байна:

3.3.1. Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, тэгш хамруулсан, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн хуулийн төсөл болон урт, дунд хугацаанд хэрэгжүүлэх салбарын зорилт, хөтөлбөр, арга хэмжээ боловсруулах, батлуулахад дэмжлэг үзүүлэх, бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөр, үнэлгээ, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, сургалтын орчин, тэгш хамран сургах боловсрол болон насан туршийн суралцахуйн талаар урт, дунд хугацаанд баримтлах бодлогын чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, батлуулах, боловсролын салбарт гадаад

улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих урт, дунд хугацааны төсөл боловсруулах, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангах, бүх түвшний боловсролын байгууллагын хүний нөөц, байгууллагын засаглал, менежмент, хөгжил, боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлт хийх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ нэгж нь үндсэн үүргийнхээ хүрээнд боловсролын салбарын урт, дунд хугацааны нэгдсэн бодлого, төлөвлөлт, хуулийн төсөл боловсруулах, норм, нормативыг боловсронгуй болгох, салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих урт, дунд хугацааны төсөл боловсруулах, төлөвлөх, нэгдсэн бодлогоор хангах, яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага хоорондын болон эдгээр байгууллага, гаднын байгууллага, судлаачдыг татан оролцуулах, зөвлөмж гаргах, удирдлагаар хангах, судалгаа, дүн шинжилгээ хийх, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын санал, тооцооллыг нэгтгэн боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд боловсролын статистик, мэдээллийн асуудал хариуцсан нэгжийн ажиллана. Энэ нэгжийн үндсэн чиг үүрэг нь статистикийн маягт, аргачлалыг боловсронгуй болгох, батлуулах, статистикийн мэдээллийг нэгтгэх, хянах, судалгаа, дүн шинжилгээ хийх, тайлагнах, тархаах, мэдээллийн санг зохицуулах, нотолгоонд суурилсан бодлого боловсруулахад шаардагдах мэдээллээр хэрэглэгчийг хангах, хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Боловсролын ерөнхий газар, Боловсролын мэдээллийн технологийн төв, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, эрдэмтэн, судлаач, иргэд, хувийн хэвшлийн байгууллагууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь холбогдох яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, төвүүд, төрийн болон төрийн бус байгууллага байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд насан туршийн суралцахуйн асуудал хариуцсан нэгж ажиллана. Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь иргэний насан туршийн суралцахуйн хөгжлийн бодлого, төлөвлөгөө, арга хэмжээг боловсруулах, удирдлага, зохицуулалтыг бодлогоор хангах, зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх, насан туршдаа суралцахуйг дэмжих, бодлого, төлөвлөлтийг удирдлага, зохицуулалтаар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, зохицуулах, мэргэжил, арга зүйгээр хангахад чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Боловсролын төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газар, насан туршийн суралцахуйн төв, багш суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж ажиллана. Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь

суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлого суралцагчийн хоол, хүнсний эрүүл ахуй, илчлэг, норм, норматив, аюулгүй байдлыг хангах дүрэм, журам, аргачлал, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, явц, үр дүнгийн мэдээлэлд шинжилгээ хийх, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүний нөөцийн хөгжил, удирдлагыг бодлогоор удирдах, зохицуулахад чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, боловсролын байгууллагууд, багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, сургуулийн өмнөх болон дээд, насан туршийн боловсрол, сургалтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд байна.

3.3.2. Дээд боловсролын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагын хөгжил, засаглал, их сургуулийг хотхон, цогцолбор хэлбэрээр хөгжүүлэх, ангилал, эрэмбэ тогтоох, чанарын баталгаажуулалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр богино хугацааны төлөвлөлт, санал, зөвлөмж боловсруулах, мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн индекс, сургалтын хөтөлбөрийн агуулгын залгамж, уялдаа холбоог хангах, сургалтын хөтөлбөрийн хэрэгцээг улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулах, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, салбарын хүний нөөцийн хөгжил, удирдлагаар хангах, салбарт хэрэгжих гадаадын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, дээд боловсролын сургалтын байгууллагын эрдэм шинжилгээ судалгааны ажлыг дэмжих, суралцагчийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургах, насан туршийн суралцахуйн талаарх богино хугацааны бодлого, төлөвлөлт, санал, зөвлөмж боловсруулах чиглэлээр зөвлөгөө, мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Боловсролын ерөнхий газар, Боловсролын мэдээллийн технологийн төв, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, дээд боловсролын сургалтын байгууллага, компани, багш, судлаач, суралцагч, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага байна.

3.3.3. Мэргэжлийн болон техникийн боловсролын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын хөгжил, засаглал, магадлан итгэмжлэл, сургалтын байгууллагыг төрөлжүүлэн хөгжүүлэх, ангилал тогтоох, чанарын баталгаажуулалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр богино хугацааны төлөвлөлт, санал, зөвлөмж боловсруулах, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн индекс, хөтөлбөрийн агуулгын залгамж, уялдаа холбоог хангах, сургалтын агуулгад сургалт-үйлдвэрлэл, үйлдвэрлэл-сургалтын шинэ

технологийг нэвтрүүлэх, улсын хөгжлийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалгатай уялдуулах, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын судалгааны ажлыг дэмжих, гадаадын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, багш, суралцагчийн хөгжил хамгаалал, тэгш хамран сургах, насан туршийн суралцахуйн талаар бодлого, төлөвлөлт, санал, зөвлөмж боловсруулах чиглэлээр зөвлөгөө, мэдээллээр хангахад чиглэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл, Боловсролын мэдээллийн технологийн төв, Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллага, сургалтын төвийн багш, суралцагч, судлаач, ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллага, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага байна.

3.3.4.Ерөнхий боловсролын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын салбарын болон тэгш хамран сургах боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хууль, гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, салбарын богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө, дүрэм, журам болон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, чанар, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүй, суралцагчийн үнэлгээ, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний бодлого, холбогдох дүрэм, журам, аргачлал, зөвлөмжийг боловсронгуй болгох, бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээлэлд шинжилгээ хийх, салбарын хүний нөөц, орчин, хэрэглэгдэхүүн, хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, арга хэмжээ, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийн явцад зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын нэгж ажиллана. Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлэх болон сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж, тэгш хамран сургах боловсролын хүртээмжтэй орчин, сургалтын тохируулгад хэрэглэгдэхүүнээр хангах, сургалт, үйл ажиллагааны чанар, салбарын хүний нөөцийн хөгжил, хүүхдийн хөгжил, төлөвшил, хамгаалал, аюулгүй байдал, сургалтын орчны чиглэлээр богино хугацааны бодлого, төлөвлөгөө, холбогдох дүрэм, журам, аргачлал, зөвлөмжийг боловсруулан батлуулах, бодлогын удирдлагаар хангах, зохицуулах, хэрэгжүүлэх чиглэлээр нутгийн захиргааны болон боловсролын сургалтын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлага, мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, багш, хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, ерөнхий, дээд болон насан туршийн

боловсрол, сургалтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд тэгш хамран сургах боловсролын нэгж ажиллана. Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь бүх шатны боловсролын байгууллагад ялгаатай хэрэгцээтэй иргэний сурч, боловсрол эзэмших эрхийг бүрэн хангах зорилгоор тэгш хамруулах боловсролын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, сургалтын байгууллагын орчны стандартыг бий болгох, шинэчлэн мөрдөх, ялгаатай, хэрэгцээтэй суралцагчид шаардлагатай ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний стандартыг тогтоож, хангамжийг сайжруулах үндсэн үүрэг хүлээж, ялгаатай, хэрэгцээтэй суралцагчтай ажиллах хүний нөөцийн хөгжлийг хангах, сургалтын зохион байгуулалтын арга хэлбэрийг оновчтой тогтоох, иргэдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамран сургах, авьяасыг хөгжүүлэх, насан туршдаа суралцахуйг дэмжих, сургуулийн орчин дахь хүүхдийн хөгжил, төлөвшил, хамгаалал, аюулгүй байдлыг хангах талаарх бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйгээр хангахад чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, ерөнхий боловсролын байгууллага, багш суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, ерөнхий боловсролын болон дээд, насан туршийн боловсрол, сургалтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд байна.

3.3.5.Цахим боловсролын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд цахим боловсролын богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийг хийх, цахим сургалтын дэд бүтэц, хэрэглэгдэхүүний бэлэн байдлыг хангах, мэдээлэл технологийн бодлогоор дэмжих, төрийн цахим нэгдсэн системд нийцүүлэх, боловсролын үйл ажиллагааг цахимжуулах, боловсролын салбарын төр, хувийн хэвшлийн байгууллагуудын мэдээллийн системийн уялдаа холбоог төлөвлөж, бодлогын удирдамжаар хангах, салбарын цахим засаглалын бодлогын баримт бичгийг боловсруулах үндсэн үүргийг хүлээж энэ хүрээнд мэдээлэл технологи, программ хангамжийн хөгжил, төрийн үйлчилгээнд инновац нэвтрүүлж, нэгдсэн бодлогоор зохицуулах, бодлого төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг бодлогын удирдамжаар хангах, Боловсролын ерөнхий газар, Боловсролын мэдээллийн технологийн төвийн хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлох, дэмжлэг үзүүлэг, удирдлагаар хангах, сайжруулахад бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Боловсролын ерөнхий газар, Боловсролын мэдээллийн технологийн төв, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, эрдэмтэн, судлаач, иргэд, хувийн хэвшлийн байгууллагууд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь холбогдох яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, төвүүд, төрийн болон төрийн бус байгууллага байна.

3.3.6. Гадаад хамтын ажиллагааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, олон улсын хурал, уулзалт зохион байгуулах, яамны гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулалтаар хангах, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, холбогдох нэгжтэй хамтран донор болон хөгжлийн байгууллагын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангах, гадаадад болон гадаадаас суралцах оюутны асуудлыг зохицуулах үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь Боловсролын салбарын гадаад хамтын ажиллагааны бодлого, зохицуулалтыг хангах, салбарын гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, олон улсын хурал, уулзалт зохион байгуулах, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, уялдааг хангах, сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад мэргэшлийн зөвлөгөө, шуурхай мэдээлэл, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны бусад газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний дэргэдэх агентлаг, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг салбарын байгууллага, иргэд байна.

3.3.7. Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд боловсролын салбарын төсвийн хүрээний мэдэгдэл, жил бүрийн урсгал болон хөрөнгө оруулалтыг газар зүйн мэдээллийн систем ашиглан оновчтой төлөвлөх, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх, салбарын эрх зүйн болон урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн төсвийн хэрэгцээний тооцоолол хийж, зардлын хүрээ боловсруулах, салбарын харьяа байгууллагын төсвийг нэгтгэн боловсруулах, удирдлага, зохицуулалтаар хангах, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн сар, улирлын болон хөтөлбөр, арга хэмжээний хуваарилалт хийх, захиран зарцуулах, тайлагнах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зохицуулалтаар хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх, гадаадын төсөл, хөтөлбөрийн төсвийн нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтыг хангах, төрийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд аудит хийлгэх, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх, шинжилгээ хийх, мэдээллээр хангах, шилэн дансны мэдээллийг хөтөлж, салбарын хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангах үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд санхүүгийн нэгж ажиллана. Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь сайдын эрхлэх асуудлын хүрээний боловсролын салбарын бодлого, үйл ажиллагааны эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх,

төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн төсвийн төсөл, төсөөллийг боловсруулах, төсвийн зардлыг нийтэд ил тод мэдээлэх, боловсролын салбарын эдийн засгийн төлөвлөлт, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн төсөл боловсруулах, холбогдох байгууллагаар батлуулах, хэрэгжилтийг хангах, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох ажлыг зохицуулах, боловсролын байгууллагын эдийн засгийн үр ашгийг сайжруулах, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бий болгон бэхжүүлэх, санхүүгийн тайланд аудит хийлгэх, төсвийн цахим шилжилтийг удирдах, зөвлөгөө, мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, дотоод аудитор, Засгийн газрын тусгай сан, Боловсролын байгууллага, эрдэмтэн, судлаач, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь Сангийн яам, бусад яамд, нутгийн захиргааны байгууллага, бүх шатны боловсрол, сургалтын байгууллага, их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллага байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалтын нэгж ажиллана. Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь сайдын эрхлэх асуудлын хүрээний боловсролын салбарын хөрөнгө оруулалтын богино хугацааны бодлого, төлөвлөлтийг бодитой, үндэслэл сайтай боловсруулах, батлуулах, бүтээн байгуулалтын төслийг газар зүйн мэдээллийн систем ашиглан төлөвлөх, худалдан авах ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах, хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрэгжих төслүүдийн зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, салбарын барилга байгууламжийн нөхцөл, эрсдэлийн судалгаа хийх, хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн цахим сан бүрдүүлэх, тайлагнах чиглэлээр мэргэшлийн зөвлөгөө, шуурхай мэдээлэл, үйлчилгээ, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, дотоод аудитор, Засгийн газрын тусгай сан, Боловсролын байгууллага, эрдэмтэн, судлаач, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Сангийн яам, нутгийн захиргааны байгууллага, бүх шатны боловсрол, сургалтын байгууллага, их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллага байна.

**3.3.8.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд Боловсролын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, яамны болон харьяа байгууллага, төслийн нэгжийн үйл ажиллагаанд болон төсөв, санхүүд дотоод аудит хийх, хяналт тавих, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, явц болон үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, байгууллагын дотоод аудит, хяналт-шинжилгээ, чанарын баталгаажуулалтыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээг цахимжуулах үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь салбарын хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, төсөв, төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, эрсдэлийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх, салбарын үйл ажиллагааг эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар бүх талын мэргэжлийн дэмжлэгийг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын байгууллага, аж ахуйн нэгж байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аудитын газар, яамд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд байна.

**3.3.9.Салбарын хяналтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 9 дүгээр зорилтын хүрээнд Боловсролын салбарын хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд тавих хяналтыг төрийн бодлого, холбогдох дүрэм, журам, стандартын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх, эрх зүйн баримт бичиг, стандартыг боловсронгуй болгох, дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, салбарын хяналтын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, салбарын хяналтыг цахимжуулахад чиглэгдэнэ.

Энэ хяналтын нэгж нь хяналт шалгалт хийж, эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр эрсдэлийн үнэлгээ тогтоох, хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, улсын байцаагчийн акт, албан шаардлага, дүгнэлт, зөвлөмж, албан даалгавар зэрэг хяналт шалгалтын баримт бичиг үйлдэн зөрчил, дутагдлыг арилгуулах, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх замаар салбарын хууль, тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилтийг хангуулах үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамд, төрийн болон төрийн бус байгууллага, боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага байна.

**3.3.10.Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 10 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны болон харьяа байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааг зохицуулах, удирдлагын манлайллыг хангах, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох, харьяа

байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, яамны болон харьяа байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээ буюу гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх, удирдлага, зохицуулалтаар хангах, төсвийн шууд захирагч нарыг томилох, чөлөөлөх асуудлыг шийдвэрлүүлэх, иргэд, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, тогтоол, шийдвэрийн биелэлт гаргах, яамны тасралтгүй, хэвийн үйл ажиллагаа болон үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, албан ёсны цахим хаягийг тогтмол хөтлөх, албан хэргийг хөтлөх, үйл ажиллагаанд удирдлагын үр нөлөөтэй арга барил, соёлыг нэвтрүүлэх, холбогдох нэгжтэй хамтран цахимжуулах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах, салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, бодлого, арга хэмжээний төсөл, түүний үзэл баримтлал, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр, гэрээ, хэлэлцээрийн төсөлд санал өгөх, тодорхой шийдлийг хамтран боловсруулах, санал болгох, боловсруулалтыг бусад хууль тогтоомжид нийцүүлэх, эрх зүйн маргаанд яамыг төлөөлөн оролцох, хууль, шүүхийн байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангуулах, хууль тогтоомжийн мэдээллийн сан бүрдүүлэх үндсэн үүрэг хүлээнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд хууль, эрх зүйн нэгж ажиллана. Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь хууль тогтоомжийн үзэл баримтлал боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төсөл боловсруулах чиглэлээр зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж, сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад цаг үеэ олсон мэргэшлийн зөвлөгөө, шуурхай мэдээлэл, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх, бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төсөв, хөрөнгийн зарцуулалтын үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, бусад яам, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд байна.